

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2025 оны сарын ...өдөр

Дугаар...

Улаанбаатар хот

Автомат клиринг хаус системээр бодит цагийн горимоор дамжих
гүйлгээний мөнгөн дүнгийн дээд хязгаарыг батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн 6.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Автомат клиринг хаус системээр бодит цагийн горимоор дамжих гүйлгээний мөнгөн дүнгийн дээд хязгаарыг төгрөг болгон нэмэгдүүлсүгэй.

2. Батлагдсан хязгаарыг 2025 оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлбөр тооцооны газар (Э.Анар), Автомат клиринг хаус системийн оролцогч нарт тус тус даалгасугай.

3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлбөр тооцооны газар (Э.Анар), Дотоод аудитын газар (А.Шижирмаа)-г тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А-252 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А-146 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Монголбанкны үйлчилгээний хөлс, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-ийн хүснэгт 1.1 дэх Банксүлжээ системд ирүүлсэн төлбөрийн даалгаварыг гүйлгээ дамжуулах цагаас хойш гүйлгээ тутамд 5,000,000.00 (таван сая) төгрөг гэснийг “Автомат клиринг хаус системээр бодит цагийн горимоор дамжих гүйлгээний мөнгөн дүнгийн дээд хязгаар” гэж өөрчилсүгэй.

6. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А-128 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Автомат клиринг хаус системийн дүрэм”-ийн 9 дүгээр хавсралтад заасан мөнгөн дүнг “Автомат клиринг хаус системээр бодит цагийн горимоор дамжих гүйлгээний мөнгөн дүнгийн дээд хязгаар” гэж өөрчилсүгэй.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.ЛХАГВАСҮРЭН